



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

“Сити тур” хотын аяллыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар, 2021 оны 11/34 дүгээр тогтоол, газрын дүрмийн 4.1.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01-р сарын 03-ны өдрийн 2022 оныг “Хотын иргэний жил болгон зарлах тухай” А/01 дүгээр захирамжийн хүрээнд “Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, зорилтод бүлгийн хүүхэд багачуудад аяллын боловсролыг олгох, эх оронч сэтгэлгээг суулгах, аяллын зөв дадлыг нэмэгдүүлэх зорилгоор “Сити тур” хотын аяллыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Сити тур” зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, аяллын маршрутыг нэгдүгээр, хотын аялал зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. “Хотын аялал”-ыг зохион байгуулахад шаардагдах автобусны шатахууны зардал 420 000 /дөрвөн зуун хорин мянга / төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500055

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 12 өдрийн
А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“СИТИ ТУР” ХОТЫН АЯЛЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
УДИРДАМЖ**

2022.04.11

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, дотоодын жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх, нийслэл Улаанбаатар хотын түүх соёл, аялал жуулчлалын үзмэр, хотын өнөөгийн хөгжилтэй танилцуулах Хүүхэд багачууд, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эх оронч сэтгэлгээг суулгах, аяллын зөв боловсролыг нэмэгдүүлэхэд тус аяллын зорилго оршино.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

1. Нийслэлийн Аялал жуулчлалын газар
2. Монголын Дауны холбоо ТББ

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Нийслэлийн тусгай зорилтод бүлгийн 6-аас дээш насны хүүхэд, асран хамгаалагч эцэг эх


ДӨРӨВ. АЯЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улаанбаатар хоттой танилцах аяллыг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн тусгай тоногдосон тохилог 2 автобусаар аяллын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. Аяллын 3 баг тус бүр дараах бүрэлдэхүүнтэй нийт 90 хүн байна.

Үүнд:

- Хүүхдүүд
- Асран хамгаалагчид
- Зохион байгуулагчид

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 14 өдрийн
А/15 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт




“СИТИ ТУР” ХОТЫН АЯЛЛЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.04.11

Улаанбаатар хот

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах ажилтан	Хамтрах байгууллага ажилтан
1	Аялал зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж батлуулах, холбогдох газруудад албан бичиг хүргэх, хотын аяллыг зохион байгуулах	2022.03.28-04.07	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг	-
2	Холбогдох газруудад албан бичиг хүргэх	2022.04.05-04.08	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг	Монголын Дуны холбоо ТББ Ажилтан Наранжаргал
3	“Сити тур” хотын аяллын автобусны бэлэн байдал техникийн аюулгүй байдлыг хангах	2022.04.06-04-15	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Ишдорж	-
4	“Сити тур” хотын аяллын автобусны жолооч, хөтөчтэй гэрээг байгуулах	2022.04.11-04.19	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Ишдорж	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Э.Оргилцэцэг
5	Үйл ажиллагааны сурталчилгааны постерны эх бэлтгэх олон нийтэд сурталчлах	2022.04.18-04.22	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн С.Туул	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Цолмонгэрэл
6	“Сити тур” хотын аяллын нээлтийг олон нийтэд сурталчлах, хэвлэлийн мэдээ бэлтгэх, нэвтрүүлэг бэлтгэх байгууллагатай холбогдох	2022.04.18-04.23	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Цолмонгэрэл	-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 13 өдрийн
А/15 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



АЯЛЛЫН ХӨТӨЛБӨР

Цаг	Зохион байгуулагдах үйл ажиллагаа	Байршил
09:00 - 09:30	Бүртгэл	Д.Сүхбаатарын талбайн автомашины зогсоол
09:30 – 09.45	Д.Сүхбаатарын талбайн хөшөө, Эзэн Чингис хааны хөшөө, эргэн тойрны барилгыг танилцуулна.	
10.00-11.30	“Астропарк” энд бид сансрын нисгэгчийн өмсгөл, оддын театр, сансрын загвар хөлөг гэх зэрэг сансар огторгуйн бяцхан аяллыг хийнэ.	“Астропарк”-ийн автомашины зогсоол
11.30-13.30	“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-ийн хөл бөмбөгийн талбайд чөлөөт цагаа өнгөрөөж хөгжөөнт тоглоом тоглоно. Үдийн цай ууна.	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн автомашины зогсоол
13.30-14.40	“Zoo and aquarium” амьтны паркаар зочлон шувуу, тогь, мөлхөгч, загас, сармагчин, сүүн тэжээлтэн гэх зэрэг амьтадтай танилцана.	“Zoo and aquarium” амьтны паркын автомашины зогсоол
15.00	Д.Сүхбаатарын талбайд ирснээр бидний аяллын хөтөлбөр өндөрлөнө.	Д.Сүхбаатарын талбайн автомашины зогсоол

--- оОо ---

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 04 сарын 12 өдрийн
A/15 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



“СИТИ ТУР” ХОТЫН АЯЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Автобусны шатахууны зардал	1	50 000*2	100 000
2	Жолоочийн зардал	2	80 000*2	160 000
3	Хөтөч тайлбарлагчийн зардал	2	80 000*2	160 000
				420 000

--- оОо ---